

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 02 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<p>Үүрэг даалгавар НЭГ: Улаанбаатар хотын “Цахим шилжилт”-ийн хүрээнд хийгдэж байгаа “Дижитал сити” болон Замын хөдөлгөөний нэгдсэн систем /RFID/-н ажлуудыг холбогдох байгууллагууд эрчимжүүлэх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн гэрчилгээг, цахим гэрчилгээгээр /RFID/ солих ажлыг олон нийтэд сурталчлан таниулах, холбогдох байгууллагууд дэмжлэг үзүүлж ажиллах.• “e-School” боловсролын нэгдсэн платформын хэвийн үйл ажиллагааг хангаж, байнгын ашиглалттай байлгах, мэдээллийн шинэчлэлтийг цаг тухай бүрд оруулж хэвшүүлэх.• Хэсгийн ахлагчийн систем нэвтрүүлэлтийн ажлыг эрчимжүүлж, хороодын үйл ажиллагаанд байнгын ашиглаж, ажиллах.• Цахим дашбоард нэвтэрсэнтэй холбогдуулан зарим байгууллагууд тоон мэдээ, мэдээллээ цаг хугацаанд нь тогтмол оруулж, системийн ажилд дэмжлэг үзүүлэх			
1	<p>Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн алба хаагчид гудамж замд үүрэг гүйцэтгэхдээ тээврийн хэрэгслийн гэрчилгээг /RFID/ цахим болгон шилжүүлэх нь иргэдэд түгжрэл болон зам тээвэртэй холбоотой мэдээлэл, автомашинаа оношлуулах болон зам ашигласны татвар төлөх, даатгалд хамрагдах хугацаа, замын засвар, түр хаагдсан зам зэргийн талаар мэдээллийг түргэн шуурхай хүргэх гол зорилготой ажил гэдгийг иргэдэд тайлбарлан таниулж, фм96.3-аар мэдээлэл өгч ажилласан.</p> <ul style="list-style-type: none">➤ Хэсгийн ахлагч нарын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Нутгийн захиргааны байгууллагын дотоод удирдлагын системд 1-24 дүгээр хороодын 206 хэсгийн ахлагч нарын хандах эрхийн тохиргоог бүрэн хийж дуусгасан.➤ 1-24 дүгээр хороодын 206 хэсгийн ахлагч нарт дата эрх бүхий утасны дугаарыг хэсгийн ахлагч нарын нэр дээр үүсгэж, Юнител ХХК-тэй гэрээ байгуулан байгууллагын нэр дээр бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.➤ Цахим системд ашиглах дата эрх бүхий дугаарын төлбөр болох 13,640,000 төгрөгийг Дүүргийн Засаг даргын Тамгын газрын зардлаас санхүүжүүлэхээр тушаалын төсөл бэлэн болсон.➤ Цахим дашбоард нэвтэрсэнтэй холбогдуулан зарим байгууллагууд тоон мэдээ, мэдээллээ цаг хугацаанд нь тогтмол оруулж, системийн ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Хэсгийн ахлагч нарын цахим систем”-нд судалгаа, мэдээ мэдээлэл оруулах			90

	<p>чиглэлээр Нийслэлийн Цахим, хөгжил мэдээлэл технологийн газраас 2023 оны 01 дүгээр сард зохион байгуулсан цахим сургалтад 1-24 дүгээр хороодын 22 зохион байгуулагчийг хамруулсан.</p> <p>➤ Хэсгийн ахлагч нарын цахим системд 1-24 дүгээр хороодын хэсгийн ахлагч нарын 1,2 дугаар сард хийгдсэн ажлын тайлан болон мэдээ, мэдээлэл оруулж, хороодын иргэн, аж ахуйн нэгж байгууллагад сурталчлан ажиллахыг Хороодын засаг дарга нарт үүрэг болгон ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагааны мэдээллийг харах боломжтой сургуулийн удирдлагуудад зориулсан “e-School”, багш нарт зориулсан eTeachHer, сурагчдад зориулсан eStudent, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан eParent хэмээх дөрвөн аппликейшнээс бүрдсэн технологийн цогц шийдэл бүхий “e-School цахим системийг 7 сургууль нэвтрүүлсэн. 2022-2023 оны хичээлийн жилийн 1 дүгээр улиралд бүх багш сурагчдын мэдээлэл болон 1 дүгээр улирлын хичээлийн дүнгүүд баталгаажиг орсон.</p>			
<p>Үүрэг даалгавар ХОЁР: Улаанбаатар хотын “Цахим шилжилт”-ийг ажлын үйл явж /Ногоон бүс/-н хүрээнд хийгдсэн ажил .</p>				
	<p>➤ Тус ажлын хүрээнд Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1, 2-р хэлтсээс 17,8 км шилэн кабель шинээр татаж камерын төвтэй холбож 1 серверийг иж бүрэн угсарч суурилууллаа. Түүнчлэн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсээс 26 дэлгэц зөөж угсрах, засварлах, тохиргоо хийх ажлыг гүйцэтгэв. Мөн 20 дэлгэцийг засварлан хэвийн байдлыг хангаж ажиллалаа. Камержуулалтын ажлын хүрээнд дүүргийн 1, 2, 3 дугаар хороодод 2тр нягтралтай 4-5 төрлийн хяналтын камеруудтай байсныг шинэчлэн MNS 6423:2019 стандартын шаардлага хангасан 4тр-тэй, өдөр шөнөгүй өнгөтөөр харах хүчин чадалтай камерыг 1-р хороонд 145 ширхэг, 2-р хороонд 125 ширхэг, 3-р хороонд 120 ширхэгийг суурилуулж камерын төвтэй холбох ажлыг гүйцэтгэлээ.</p> <p>➤ Цагдаагийн 1, 2-р хэлтэст өмнө нь NVR буюу /нетворк видео рекординг/ хэрэглэж байсан. Энэ нь мэргэжлийн бус ахуйн түвшний зориулалттай байсныг шинэчлэн Нэг цэгийн төвд мэргэжлийн, зориулалтын 12-р үеийн I5 CPU-тэй 32Gb рамтай мэргэжлийн сервер ашиглаж эхэллээ. Ингэснээр гацалтгүй, бичлэгийн чанар өндөр нягтралтайгаар хадгалагдах боломжтой болж байгаа. Өмнө нь 1-р хэлтэст 56Tb багтаамжтай /бичлэг хадгалах/, 2-р хэлтэст 72Tb багтаамжтай байсныг шинэчлэн 256 Tb болгосон бөгөөд ингэснээр бичлэгийг 60 орчим хоног хадгалах боломжтой болсон.</p> <p>➤ 1-р хэлтэс 10 дэлгэцтэй, 2-р хэлтэс 16 дэлгэцтэй. Үүнээс 1-р хэлтсийн 3 дэлгэц эвдэрхий, 2-р хэлтсийн 3 дэлгэц эвдэрхий байсан. Шинээр хяналтын камерын зориулалтын 24/7 үзүүлэлттэй 4 дэлгэцийг суурилууллаа.</p> <p>Цаашид зураггүй зориулалтын бус шилэн кабелиудыг их хэмжээгээр татсан байсныг шинэчлэн 1 хороонд тойрог хэлбэрийн сүлжээ байгуулж 8-12 цэг үүсгэж үүсгэсэн цэгүүдэд хяналтын камеруудыг холбодог болно. Ингэснээр дахин хяналтын камер нэмж суурилуулах, өргөтгөхөд дахин шилэн кабель, дэд бүтэц татах шаардлагагүй болох юм. Мөн 2023 онд</p>		<p>90</p>	

Чингэлтэй дүүргийн 4, 5, 6, 7, 9, 10, 12, 21, 16, 20, 22, 19, 24 дүгээр хороодыг камержуулж Ногоон бүс болгоно.			
Үүрэг даалгавар ГУРАВ: Сургуулийн автобусны хяналтын цахим системийг нэвтрүүлсэнтэй холбогдуулж 40 сургуулийн 110,000 сурагчдын карт буюу үнэмлэхийг байнгын ашиглалттай байлгах, багш, эцэг эхчүүдэд бодит мэдээллийг цаг тухай бүрд хүргэхэд анхаарч, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.			
Дүүргийн ЕБС -ийн 17 сургуулиас 6 сургуулийн 935 суралцагч чиглэлд зорчиж байснаас 2022 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлаас 1. Гандан-Телевизийн эцэс- Баянхошуу хөтөл-149 дүгээр сургууль , 2. 32-ын тойрог-Хайлаастын шинэ эцэс -49 дүгээр сургууль, 3.72 дугаар сургууль-Хайлааст усан сан, 72 дугаар сургууль-Хайлааст усан сан, 4.Чингэлтэйн эцэс Зүрх -Уул-37 дугаар сургууль, 5. Яргайт- Салхит Гоодойн ам-7 буудал-117 дугаар сургууль, 6. Чингэлтэйг эцэс Зүрх -Уул-7 буудал-140 дүгээр сургууль нийт 7 чиглэлд 7 автобус 1904 сурагч явахаар төлөвлөн ажиллаж байна.			70
Үүрэг даалгавар ДӨРӨВ: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд гэр хорооллын бүсийг “Ногоон бүс” болгох ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлаа эрчимжүүлж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.			
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд гэр хорооллын бүсийг “Ногоон бүс” болгох ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний төслийг боловсруулан ажиллаж байна. Тус ажлын төлөвлөгөөнд Шинжлэх Ухааны Академийн газарзүй геоэкологийн хүрээлэнтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд гэр хорооллын бүсэд хөрсний судалгаа хийж, хөрсөнд тохирсон мод бут сөөгийг тарихаар тусган ажиллаж байна.			90
Үүрэг даалгавар ТАВ: Иргэд, олон нийтийн амгалан тайван байдлыг хангаж, гал түймрийн аюул осол, гэмт хэрэг, зөрчилд өртөх болон зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний ачаалал ихтэй уулзваруудаа сайтар зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.			
Чингэлтэй дүүргийн Засаг даргын Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай А/341 дүгээр захирамж, нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13/101 тоот албан бичиг “Нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, дүүргийн Цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн дарга, Онцгой байдлын хэлтсийн дарга, Таван толгой түлш ХХК-ийн хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга нарын баталсан Чингэлтэй дүүргийн 10-24 дүгээр хорооны гэр хорооллын айл өрхүүдэд, галын аюул угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөний дагуу гал түймрийн эрсдэлийг бууруулах угаарын хийн хордлогоос иргэдийг хамгаалах зорилгоор нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж 10-24 дүгээр хорооны иргэдэд заавар зөвлөгөө өгч, санамж сэрэмжлүүлгийн материал тарааж ажилласан. Нэгдсэн арга хэмжээнд Онцгой байдлын хэлтсээс 20 алба хаагч, дүүргийн Цагдаагийн газрын 2 дугаар хэлтсээс 20 алба хаагч, Таван толгой түлш ХХК-аас 50 ажилтан, хороодын Засаг даргын ажлын албаны 20 ажилтан давхардсан тоогоор нийт 1100 ажилтан алба хаагч 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл өдөр бүр			90

<p>ажиллаж 7-24 дүгээр хорооны 11550 айл өрх, 245 аж ахуйн нэгж байгууллагад үзлэг, шалгалт зохион байгуулж 19764 зөрчил дутагдал илрүүлж пийшин зуухны аюулгүй байдал, угаар мэдрэгчийн бүрэн бүтэн байдал, цахилгаан дамжуулах утасны аюулгүй байдал, зам гарц хааж хашаа сунгасан болон шинээр хашаа барьсан зөрчилд хяналт тавьж гарч болзошгүй гамшиг осол, гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 5000 ширхэг зурагт хуудас, 4500 ширхэг гарын авлага тарааж иргэдэд галын аюулгүй байдал, цахилгааны аюулгүй байдал, пийшин зуухны бүрэн бүтэн байдлыг хангах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Мөн Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг ХҮЧИТ ШОНХОР худалдааны төвийн гадна талбайд сар шинийн баярыг угтаж ГАЛ ТҮЙМЭР, УГААРЫН ХИЙН ХОРДЛОГООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр нийт 1170 иргэнд гамшиг осол, гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, аюулгүй галлагаа болон цахилгааны аюулгүй байдлаа хангах талаар заавар зөвлөгөө өгч 3450 ширхэг санамж сэрэмжлүүлэг тарааж ажилласан. http://chd.nema.gov.mn/ сайт болон ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТЭС пэйж хуудсаар сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг даалгавар ЗУРГАА: Томоохон захуудад болон худалдааны төвүүдэд хүнсний аюулгүй байдлыг хангаж, хяналт тавьж ажиллах.</p>			
<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын “Зах, худалдааны төвүүдэд хяналт хийх тухай” удирдамж батлагдсан.</p> <p>Удирдамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт зах, худалдааны төвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 2 дугаар хороо “Саруул Орд” ХХК-ийн Алтжин Бөмбөгөр, “Эрдэнэбулган” ХХК-ийн Содон Бамбөгөр, “Юмт Бөмбөгөр” ХХК-ийн Юмт Бөмбөгөр, 11 дүгээр хороо “Хүчит Шонхор” ХХК-ийн Шонхор, “Мөнгөт Цахир Трейд” ХХК-ийн Нарлаг Дэнж, “Замилан-таяа Мэд” ХХК-ийн Дөрвөн Шонхор, 12 дугаар хороо “Анко” ХХК-ийн Нарантуул 2 нийт 7 зах, худалдааны төв хяналтад хамрагдсан.</p> <p>Тус байгууллагуудад 2023 оны 02 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, дүүргийн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга хамтран эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлт, худалдан борлуулж байгаа хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, зах, худалдааны төвийн орчимд хүнсний болон хүнсний бус ил задгай худалдаа эрхлэгч нарт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Хяналтаар зах, худалдааны төвд хүнсний чиглэлээр худалдаа эрхэлж байгаа иргэд малгай, хормогч, нэг удаагийн бээлий өмсөж хэвшээгүй байсан тул илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулан ажилласан.</p>			90
<p>Үүрэг даалгавар ДОЛОО: Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө, сэрэмжлүүлгийг айл өрхүүдийг тогтмол өгч, сайжруулсан түлшээр тасалдуулахгүй хангаж ажиллах.</p>			

<p>Сайжруулсан шахмал түлшийг хэрэглэх заавар зөвлөгөө, сэрэмжлүүлгийг тогтмол дүүргийн цахим хуудас болон “Тохижилт үйлчилгээ”ХХК, “Найши трейд”ХХК-тай хамтран дуут бичлэгийг тогтмол өгөн ажиллаж байна. 2023 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 19 цагийн байдлаар сайжруулсан шахмал түлш борлуулах борлуулалтын 87 цэг сайжруулсан шахмал түлшний нөөцтэй, 5 цэг түлшний нөөцгүй байна. Дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш борлуулах цэгүүдэд нийт 921 тонн түлшний нөөцтэй байна. Дүүргийн хэмжээнд агуулахаас 11321.5 тонн түлшийг цэгүүдэд нийлүүлэн 1750 тонн түлшний нөөцтэй байна.</p>			90
<p>Үүрэг даалгавар НАИМ : Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, урьдчилан сэргийлж ажиллах.</p>			
<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 18 өдрийн А/373 дугаар тушаалын дагуу Хүүхдийн тасгийн орны ачаалал нэмэгдсэнтэй холбогдуулан мэдрэл, уламжлалтын тасгийн орыг хүүхдийн тасаг руу шилжүүлсэн. Хүүхдийн өвчлөл эрчимтэй нэмэгдэн орны эргэлт удааширсан тул нэмэлтээр дотрын тасгийг чөлөөлж хүүхдийн 150 ор дэлгэн, дотоод зохион байгуулалт хийн ажиллаж байна.</p> <p>2023 оны 02 дугаар сарын 06 өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хүүхдийн амбулаторд 335, хүүхдийн хүлээн авахаар 639 нийт 974 хүүхдэд үзлэг хийж, 337 хүүхдийг хэвтүүлэн эмчлүүлсэн. Хүүхдийн тасагт эмчлэгдсэн хүүхдийн мэдээллийг өдөр бүр өрхийн эрүүл мэндийн төвүүд рүү илгээж, гэрийн эргэлтийг эрчимжүүлэн ажиллаж байна.</p> <p>Молекул биологийн лабораторид томуугийн А,В хүрээний вирус тодорхойлох тандалтын шинжилгээг хийж лабораторийн эмч, лаборант нарыг сургалтад хамруулан, томилгоожуулан үйл ажиллагааг эхэлсэн. Томуу, томуу төст өвчний вирусын хэв шинжийг илрүүлэх зорилгоор нийт 234 сорьцод тандалтын шинжилгээ хийхэд 150 сорьцод /64%/ А,В хүрээний томуугийн вирус болон RSV илэрсэн.</p> <p>Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/10 дугаар тушаалын дагуу “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье” өдөрлөгийг зохион байгуулж, 2023 оны 02 сарын 03-ний өдөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн 36 эмчид томуу, томуу төст өвчин болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчилгээний сургалт хийсэн. Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн амбулаторийн 3 салбарт иргэдэд Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж өгч, маскаа тогтмол зүүхийг 750 иргэдэд уриалан гарын авлага, ном,товхимол, 1500ш утааны шүүлтүүртэй рм 2.5-тай маск, витамин С иргэдэд олгон ажиллаа. Дүүргийн хэмжээнд “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлье” сэдэвт мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэх 2 сарын аяныг 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс зарлаж, өдөрлөг зохион байгуулахаар ажиллаж байна.</p>			90
<p>Үүрэг даалгавар ЕС : Инженерийн шугам сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж, ус, дулаан, цахилгаан хангамжаар байгууллага, иргэдийг тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлэх.</p>			
<p>1. Шуурхай ажиллагааны бригад, жижүүрийн хуваарийг гарган, хяналт тавьж, болзошгүй осол, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх.</p>			

2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, хог хаягдлуудыг цэвэрлэх, тээвэрлэх ажлыг зохион байгуулж, хотын гудамж, талбайн гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж ажиллах.

“Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 8.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн салбарын даргын А/03 тоот тушаалаар батлагдсан Баярын өдрүүдэд инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах, ажил үйлчилгээг шуурхай явуулах зорилгоор хариуцлагатай эргүүлээр ажиллах инженерүүд болон нэмэгдэл засварчид, цахилгаанчдад гэмтэл саатлын үед шаардагдах материал сэлбэг тоног төхөөрөмжийг нөөцөд бэлэн байлгаж ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах орон сууцны 115 байрны 6609 өрх, 676 аж ахуйн нэгж байгууллагад, 26-н бага чадлын Ус Дулаан Дамжуулах төвөөр дамжуулан 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаагаар ус, дулаан, цахилгаанаар хангаж, бохир ус татан зайлуулж, тэдгээрийн найдвартай ажиллагаа, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

2- Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, “Найши трейд” ХХК хариуцсан зам талбайн цэвэрлэгээ, авто замын халтиргаа, гулгааг арилгах чиглэлээр ажиллалаа. 2023 оны 02 дугаар сарын 20-ны байдлаар нийт 155 зам талбайн үйлчлэгч, ажилтнууд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цас мөс халтиргаа гулгааг тогтмол цэвэрлэн ажиллаж байна. Мөн давс, бодис цацах, замын нуухын цэвэрлэгээ хийх тусгай зориулалтын 6 камаз, 4 шүүрдэгч техник, ковш 4, үлээгч төхөөрөмж 4 гэсэн техник хэрэгсэлтэйгээр цэвэрлэгээнээс гарсан цасыг 20 машинтайгаар тогтмол тээвэрлэн ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК төвийн бүс болон гэр хорооллын төв болон туслах замуудад нийт 98 тонн давс, 15м3 дайрга болон 2 тонн бодис цацан нийт 130 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 8 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж байна. “Найши трейд” ХХК зуслангийн бүс болох Ойн жим, Шадивлан, Яргайт, Яргайтын богино, Жигжид чиглэлийн авто замуудад халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлэх зорилгоор 8 тонн давс, 2 тонн бодисыг 3 техник хэрэгсэл, 16 хүний бүрэлдэхүүнтэй зам талбайн цэвэрлэгээг тогтмол гүйцэтгэн ажиллаж байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвд дүүргийн нутаг дэвсгэр дэх инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, цахилгаан хангамжаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг тасалдуулахгүй байхад анхаарч, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлж ажиллах, гэмтэл, саатлыг засварлах шуурхай ажиллагааны бригад, жижүүрийн хуваарь гарган үйл ажиллагаанд нь хяналт тавьж хамтран ажиллах тухай 3/394 тоот албан бичиг хүргүүлсэн.

Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх төв-6-д дүүргийн нутаг дэвсгэр дэх инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, ус дулаан хангамжаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг тасалдуулахгүй байхад анхаарч, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлж ажиллах, Гэмтэл, саатлыг засварлах шуурхай

ажиллагааны бригад, жижүүрийн хуваарь гарган үйл ажиллагаанд нь хяналт тавьж, хамтран ажиллах тухай 3/395 тоот албан бичиг хүргүүлсэн.			
--	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЭНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ